

**“Силикат” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл.**

2025 оны 04 сарын 24



Дархан уул аймаг

“Силикат” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал Дархан уул аймгийн “Силикат” ХК-ийн хурлын зааланд 2025 оны 04 сарын 24-ны өдөр 10 цагт эхлэв.

Хурлын ирц:

Нэрс Хувь	Эзэмшиж буй хувьцааны тоо
1. Ц.Содбилэг 16,21%	7,511,526 ш
2. Ц.Сэргэлэн 0,97%	451,704 ш
3. С.Золбоотөгс /итгэмжлэлээр/ 14,12%	6,539,619 ш
4. Ц.Содбилэг/итгэмжлэлээр/ 12,3%	5,699,223 ш
5. В.Мөнхтуяа 7,8%	3,613,455 ш
6. Силикат ХК 34,17%	15,832,926 ш
Нийт 85.57%	40 648 453 ш

Хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт хувьцааны 85.57.5% буюу 40 648 453 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдхүүнтэй хуралдлаа.

В.Мөнхамгалан: Өнөөдрийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ.

1. Компанийн санхүүгийн тайлан, Хараат бус аудитын дүгнэлт, тайлан.
2. -Компанийн 2024оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.
3. - Компанийн нэрийг өөрчлөн Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгох, нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах
4. - ТУЗ-ийн төсөв.
5. ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилох

Хэлэлцэх асуудлаа батлах уу ? батлана гэсэн нь гараа өргө. /100% гараа өргөв/
Баталлаа.

За Хурлын дэгийг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал дээрээ ажлын комисс гаргах ажиллах байх гэж бодож байна.
Комиссоо томилоод явчих уу эсвэл хурлынхаа явцад томилох уу? /бүгд ярилцаж

хурлынхаа явцад комисс томилохоор шийдэв/. Асуултаа асуугаад саналаа хэлээд зэрэг явуулах уу эсвэл асуултаа асуугаад санал нь тусгаад явах уу? Миний бодлоор асуултаа асуугаад саналаа хэлээд явчихвал яаж байна? /хүмүүс зөвшөөрч асуултаа асуугаад саналаа хэлээд зэрэг ярилцахаар болов/. /Хүмүүс 100% зөвшөөрч хурлаа эхлэв/.

Ц.Содбилэг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд илтгэл тавив.

Өнгөрсөн 2024 онд 04 сард үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэсэн. Гэвч төлөвлөгөөнд заасан ажлууд хараахан хугацаандаа хийгдэж чадаагүй. Гол түүхий эд болох шохойны чанар муудаж гарц багассанаас шалтгаалан үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна.

Мөн Компанийн санхүүгийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай та бүхэн танилцсан байх. 2024 онд бид хүчин чадлаа нэмэгдүүлэх зорилгоор шохойн үйлдвэрлэлдээ илүү анхаарч ингэснээр үйлдвэрлэлтийн хүчин чадал маань нэмэгдэнэ гэж үзэж байна. Үүнтэй холбоотой сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж ажлын тайлантай бас танилцсан байх.

- Шохойн үйлдвэрлэлийн хүчин чадлын гарцыг нэмэгдүүлэх, Бүтээгдэхүүний борлуулалт талаар дэлгэрэнгүй илтгэл тавив.
- Компанийн нэрийг өөрчлөн ХХК болгох төсөл, нэгж хувьцааг эргүүлэн авах саналыг тавилаа.
- ТУЗ-ийн зарим нэр бүхий гишүүдийг улируулан сонгож, зарим гишүүдээр гишүүний үүргээс чөлөөлж, шинээр томилогдож буй гишүүдийг томиллоо.

ТУЗ-ийн гишүүн Ц.Болормаа: Хурлаар хэлэлцэгдэх асуудлууд дээр бүгдийг санал нэгтгэйгээр дэмжиж байна.

Ц.Содбилэг: Бид энэ 2025 онд компаниа ХХК болгоё гэсэн санал маань компанийг ХХК болгох хүртэл хэлэлцэгдсээр байх болно. Энэ асуудал маш олон жил яригдсаар ирсэн боловч компанийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалж өнөөдрийн хүртэл шийдвэрлэгдэж чадаагүй байгаа. Одоо манай компани нийт хувьцааныхаа 99.7 хувийг нэгдмэл сонирхолтойгоор эзэмшиж байгаа учраас үлдсэн хувьцааг эргүүлэн худалдаж авна гэж төлөвлөөд төсөл боловсруулсан байгаа та бүхэн танилцаад саналаа хэлээрэй.

ТУЗ-ийн гишүүн В.Мөнхтуяа: Хурлаар хэлэлцэгдэж байгаа асуудлуудыг дэмжиж байна. Компаний нэрийг өөрчлөн ХХК-г болгох асуудалыг мөн дэмжиж байна. Үлдсэн нэгж хувьцаагаа татан төвлөрүүлж ХХК болгох нь зүйтэй. Дээрх асуудлыг хариуцан ажиллахыг захирал Ц. Содбилэгт хариуцуулан ажиллуулах саналтай байна. ТУЗ-ийн шинээр орж байгаа гишүүдийг мөн дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн Р.Энхтайван: Оруулсан саналуудыг дэмжиж байна. ТУЗ-ийн төсөвийг одоо оруулж байгаа хэмжээгээр нь батлах саналтай байна. Цаашдаа компаниа ХХК болгох нь зүйтэй. Төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг захирал Ц. Содбилэг хариуцан ажиллах саналыг мөн дэмжиж байна.

С.Золбоотөгс: Ер нь бол нийт хувьцааныхаа 99,7 хувийг эзэмшиж байгаа учраас цаашид ХХК болгох нь зөв. Хурлаар хэлэлцэгдсэн асуудлыг санал нэгтгэйгээр бүгдийг дэмжиж байна.

В.Мөнхамгалан: Өөр нэмж асуух, лавлах зүйл байна уу?

В.Мөнхамгалан: Саналаа хураах.

В.Мөнхамгалан: За хэлэлцсэн энэ асуудлаараа саналаа явуулъя. Зөвшөөрч байгаа нь гараа өргөнө үү.

-100 хувь гараа өргөж батлав.

Тооллогын комиссын дарга Б.Энхтуул : Тооллогын комиссын тогтоол гарлаа.

Силикат ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт хувьцааны 85,57.% буюу 40 648 453 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдхүүнтэй хуралдаж санал хураалтанд дараах шийдвэр гарав. Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 85.57% буюу 40 648 453 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар авсан ба 5 буюу 100% хүчинтэй байлаа. Хэлэлцсэн асуудлаар бүгд 100% зөвшөөрсөн, татгалзсан түтгэлсэн байхгүй байна.

Хурал 12 цагт дуусав.

Хурлын тэмдэглэл хөтлөсөн



Б.Энхтуул